# ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГАН-2018

***Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд***




## 2018 ОНЫ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ, СОРИЛТУУД

# АГУУЛГА


## 1 Удиртгал

Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд

## 2 Эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв

Макро эдийн засгийн 2018 оны төлөв байдал

## 3 Бидний өмнө тулгарч буй үндсэн 3 сорилт

Улсын гадаад өрийн дарамт
Ядуурал, өрхийн өр зээлийн дарамт
Байгалийн баялагийг эдийн засгийн хөгжилд ашиглах

## 4 Дүгнэлт

Бодлогын үр дүн цаг хугацаа, хамрах хүрээнээс хамаардаг.

- Монголын эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв байдал, сорилтуудаа дүгнэн хэлэлцэж, цаашдын хамтын ажиллагаа, бодлого, зөвлөмжийг тодорхойлох явдал чухал юм.

- Шинэ оны босгон дээр эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй тааламжтай буюу хүндрэлээс хэдэн алхам холдоод байна.
  - 2017 онд эдийн засаг 5-6 хувьтай өсч, гадаад валютын нөөц 3 тэрбум ам.долларт хүрсэн, инфляци зорилтот 8 хувийн түвшинд хадгалагдсан.

- Гэхдээ бодлого боловсруулагчдын өмнө том сорилтууд шийдлээ хүлээсэн хэвээр байна.

- Энэхүү өгүүллээр 2018 оны эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв байдал, хүлээгдэж буй 3 том сорилтын талаар саналаа солилцож байна.

## Зураг 1. Эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: ҮСХ

2017 оны эхний 3 улирлын байдлаар **ДНБ-ий өсөлт 5.7 хувь** байна.

- Нүүрсний үнийн сэргэлт,
- Эдийн засгийн төлөвийн талаарх эерэг хүлээлт, итгэл сэргэсэн.

## Зураг 2. Үйлдвэрлэлийн зөрүү




Эх сурвалж: Монголбанкны тооцоо

Эдийн засгийн идэвхжил нь **уул уурхайн бус салбарын** үйлдвэрлэлээр тодорхойлогдож байна.

## Хүснэгт 1. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

| Он | 2015 | 2016 | 2016 Q3 | 2017 Q2 | 2017 Q3 |
|---|---|---|---|---|---|
| Ажиллагсад (мян. хүн) | 1067.6 | 1132.8 | 1144.4 | 1237.7 | 1190.9 |
| *жилийн өсөлт* | *2.6%* | *6.1%* | *2.2%* | *9.4%* | *4.1%* |
| Хөдөө аж ахуй | 335 | 352 | 385 | 357 | 343 |
| Аж үйлдвэр | 207 | 209 | 200 | 251 | 237 |
| Худалдаа | 154 | 173 | 165 | 199 | 188 |
| Үйлчилгээ | 371 | 399 | 394 | 431 | 424 |
| Ажилгүй иргэд (мян. хүн) | 96.5 | 107.0 | 118.9 | 132 | 119 |
| *жилийн өсөлт* | *10.9%* | *10.9%* | *57.0%* | *-0.1%* | *-0.1%* |
| Ажиллах хүчний оролцоо, % | 60.5 | 60.4 | 61.6 | 61.6 | 61.1 |
| *жилийн өөрчлөлт* | *0.2* | *-0.1* | *0.2* | *1.3* | *-0.5* |
| Ажилгүйдэл, % | 8.3 | 8.6 | 9.4 | 9.6 | 9.1 |
| *жилийн өөрчлөлт* | *0.6* | *0.3* | *3.1* | *-0.8* | *-0.3* |

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн сэргэсэн нь ажил эрхлэлт нэмэгдсэн хэдий ч **ажилгүйдэл өндөр түвшинд байсан хэвээр** байна.

## Зураг 3. Иргэд, хувийн хэвшлийн зээлийн өсөлт




*Эх сурвалж:Зээлийн тайлан, 2017 оны 11 дүгээр сар, Монголбанк*

## Зураг 4. Чанаргүй зээл, түүний өөрчлөлт




## Зураг 5. Инфляци, түүний задаргаа




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

2017 онд иргэдийн зээл, тэр дундаа **цалин, тэтгэврийн зээл өсөлттэй гарсан** бол **аж ахуйн нэгжүүдийн зээлийн өсөлт сөрөг** байлаа.

Нийт чанаргүй зээлийн хэмжээ 2017 оны 2 дугаар хагаст **биет хэмжээгээр өсөөгүй** .

Үйлдвэрлэл, инфляцийн динамикаас харахад эдийн засаг уналтын мөчлөгөөс гарч сэргэлтийн төлөвт шилжээд байна.

## Зураг 6. Төсвийн төлөв болон төсвийн импульс




*Эх сурвалж: Монголбанк*

## Зураг 7. Мөнгөний бодлогын хүү




## Зураг 8. Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны хүү




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

Төсөв алдагдалтай байгаа боловч, өмнөх оноос **чангарч байгаа нь** эдийн засгийн өсөлтийг сааруулах чиглэлд нөлөөлж байна.

Эдийн засгийн дотоод эрэлтийг дэмжих зорилгоор **мөнгөний бодлого** сүүлийн 1 жилийн хугацаанд **сулрав**.

Бодлогын хүүний бууралт нь **ЗГҮЦ-ны хүү буурахад** нөлөөлж байна.

## Зураг 9. Гадаад эдийн засгийн төлөв

### Төлбөрийн тэнцэл




### Гадаад валютын нөөц, түүний хүрэлцээ




### Экспорт, импортын үнийн индекс




### ТТ-ийн санхүүгийн дансны тэнцэл




2017 онд урсгал болон хөрөнгийн дансны тэнцэл алдагдалтай, харин санхүүгийн тэнцэл ашигтай гарав.

Гэхдээ нийт төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын нөөц нэмэгдэв.

**Гадаад эдийн засаг**

Инфляци, эдийн засгийн өсөлт

Гадаад эрэлт 2018 оны II хагасаас буурахаар байна.

Худалдааны нөхцөлийн жилийн өөрчлөлт 2018 оны II хагаст сөрөг байхаар байна.

**Зураг 10. Гадаад эрэлтийн өөрчлөлт, хувиар**




*Эх сурвалж: Монголбанкны тооцоо*

**Зураг 11. Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт**




*Эх сурвалж: Монголбанкны тооцоо*

Гадаад эдийн засаг

**Инфляци, эдийн засгийн өсөлт**

- Инфляцийн цэгэн таамаглал 8 хувийн зорилтот түвшний ойролцоо байхаар байна.
- Эдийн засгийн өсөлт 2017 оны түвшнээс буурахааргүй байна.
- Инфляци, ДНБ-ий өсөлтийн төсөөлөлд тодорхой бус байдал өндөр байна.

**Зураг 12. Инфляцийн төсөөлөл**




*Эх сурвалж: Монголбанк*

**Зураг 13. Улирлын ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл**




*Эх сурвалж: Монголбанк*

- Монгол улсын гадаад өрийн дарамт,
- Монголчуудын ядуурал, өр зээлийн төлбөрийн дарамт,
- Байгалийн баялгийг эдийн засгийн хөгжилд ашиглах.

# СОРИЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨРИЙН ДАРАМТ

- Гадаад өрийн тогтворгүй байдал -> улсын эдийн засгийн аюулгүй байдал, тусгаар тогтнол.

- Улсын өрийн дефолтоос зайлсхийх сонголт -> ОУВС болон бусад донор орон, санхүүгийн байгууллагуудын тусламж авах байв: "Үүлэн чөлөөний нар".

- Өр, төлбөрийн "чөтгөрийн тойрог"-оос гарахгүй бол -> улс орны хөгжил доройтож, тусгаар тогтнолд аюул заналхийлнэ.

- Иймд гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, дотоодын нөөц бололцоог бүрэн ашиглах шаардлагатай:
  - Том ордны IPO хийх, концессоор өгөх,
  - Эдийн засгийн төрөлжилт: ноолуур дээр бүх бооцоогоо тавих,
  - Дэлхийд толгой цохих шинэ технологи гаргах/нэвтрүүлэх.

**Зураг 14. Гадаад өр, салбараар, тэрбум ам.доллар**




**Зураг 15. Монголбанкны гадаад валютын нөөц , сая ам.доллар**




*Эх сурвалж: Монголбанк*

# СОРИЛТ 2. МОНГОЛЧУУДЫН ЯДУУРАЛ, ӨР ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙН ДАРАМТ

- Ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувь, 2016 онд 29.6 хувь (с.х нь 0.7) болж нэмэгдсэн.

  Өрхийн өр, ДНБ-ий харьцаа сүүлийн 5 жилд 2 дахин өссөн.

- Өрхийн өр өсөхийн хэрээр макро шоконд өртөх эмзэг байдал нэмэгдэж, санхүүгийн тогтвортой байдалд аюул занал бий болгож байна.

  Өрийн өсөлт үргэлжилбэл бодлогын хариу арга хэмжээ зайлшгүй болно.

## Зураг 16. Өрхийн нийт өр болон 4 улирлын нийлбэр ДНБ-ий харьцаа




## Зураг 17. Өрхийн өрийн дүн /2017 оны 3 дугаар улирал/




## Зураг 18. Өрхийн зээлийн жилийн өсөлт /гол төрлүүдээр/




*Эх сурвалж: Цэнд-Аюуш, Ганчимэг болон Энхбаатар (2017)*

# СОРИЛТ 3. БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД АШИГЛАХ

| Байгалийн баялагт тулгуурлан амжилттай хөгжих шат дамжлага | Шат дамжлага бүрт тулгарах хүндрэл, шийдэл |
|---|---|
| Байгалийн нөөцийг нээн илрүүлэх | • Байгалийн нөөцийг нээн илрүүлэх (олборлолт, ашиглалт) дотоод нөөц боломж хомс: **Одоогоор нээн илрүүлээд байгаа том ордуудаа ашиглаж эхлэх** |
| Байгалийн нөөцийг ашиглах: хөрөнгө оруулалт татах | • Бага орлоготой, байгалийн баялагтай орнууд нь ерөнхийдөө хуримтлал багатай: **Монголчууд өөрсдөө IPO гаргах, Концессоор өгөх (төрийн чадавхи сул, мэдлэг боловсролын хоцрогдол)** |
| Байгалийн нөөцийн орлогыг тогтвортой байлгах | • Байгалийн баялагийн орлогыг хөрөнгө оруулагч, засгийн газар болон бусад оролцогчид хэрхэн хуваах тохиролцоо: **Ил тод, нээлттэй байх засаглал, институци бүрдүүлэх (Баялагийн хараалаас зайлсхийх)** |
| Байгалийн нөөцийн орлогоор оновчтой хөрөнгө оруулалт хийх | • Хөрөнгө оруулалт бус өнөөдөр зарцуулах дарамт: **Бидний сургамж**<br>• Төслүүдийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд мөн л хүндрэлтэй: **Том төсөл, дэд бүтэцд хөрөнгө оруулах**<br>• Улс төр, авлига, хээл хахууль: **Засаглал, институци** |
| Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх: тогтвортой өсөлтийн суурь бүрдүүлэх | • Бусад худалдаалагддаг салбарууддаг сөрөг нөлөө үзүүлдэг: Экспортыг дэмжих -> Гадаад валютын нөөц<br>Хүмүүн капитал, дэд бүтэцд хөрөнгө оруулах<br>Нөөцийн салбартай уялдаатай, өрсөлдөх чадвартай салбаруудыг дэмжих |



Эдийн засаг уналтаас дайжиж, тогтворжиж эхлээд байгаа боловч тогтворжилтыг батжуулах, тогтвортой өсөлтөд оруулахад тууштай бодлого шаардлагатай хэвээр байна.

- 2018 онд эдийн засгийн өсөлт үргэлжилж, инфляцийн дарамт бага зэрэг нэмэгдэхээр байна.
- Эдийн засагт гадаад секторын болон бодлогын сорилтуудыг хэрхэн шийдвэрлэхтэй холбоотой тодорхой бус байдал байна.

Бодлогын үр дүн нь шийдвэр гарах ёстой цаг үед (үүлэн чөлөөний нарыг ашиглан)-ээ, хамрах ёстой хүрээгээ зөв хамарсан эсэхээс шууд хамаардаг.

Шаардлагатай шийдвэрүүд (гадаад өрийн дарамтыг шийдвэрлэх, өрхийн өр, зээлийн дарамтыг багасгах, байгалийн баялагтаа тулгаарлан эдийн засгаа төрөлжүүлэх)-ийг судалгаа, шинжилгээнд үндэслэн шуурхай гарган хэрэгжүүлснээр улс орны хөгжлийг түргэсгэнэ гэдэгт эргэлзэхгүй байна.